МЭДЭЭ · 2022 оны 4-р сарын 28

# НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЖ БАЙГАА ИРГЭДЭД СУРГАЛТ ХИЙЖЭЭ




Хөвсгөл аймгийн прокурорын газраас нийтэд тустай ажил хийж байгаа иргэд болон Хөвсгөл аймгийн "Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв" ХХК-ийн алба хаагчдад "Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, ялаас зайлсхийсэн тохиолдолд гарах хууль зүйн үр дагавар, ажил олгогч байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага"-ын талаар сургалт хийжээ.

Сургалтаар нийтэд тустай ажил хийж байгаа иргэдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилга өгч ажиллах, иргэдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах талаар мэдээлэл өгсөн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2503